

Монгол улсын Боломж Олгох Сан - I

Улс:	Монгол
Төслийн дугаар:	41357
Бизнесийн салбар:	Хувьцаа хөрөнгө оруулалт
Төрийн/Хувийн:	Хувийн
Байгал орчны ангилал:	FI
Зөвлөлийн хурлаар орсон өдөр:	2010 оны 7-р сарын 20
Төслийн үе шат:	Эцсийн хяналтыг давсан, Зөвлөлийн хурлаар батлуулах шаардлагатай
Төслийн баримт бичгийг олон нийтийн хүртээл болгосон өдөр :	2010 оны 7-р сарын 17

Төслийн танилцуулга

ЕСБХБ нь Монгол улсын анхны Боломж Олгох Санд (цаашид Сан гэнэ) 10 сая ам. доллартай тэнцэх хөрөнгө оруулалтыг хувьцаа худалдан авах хэлбэрээр хийх гэж байна. Энэхүү хөрөнгө оруулалт нь Сангийн нийт хөрөнгийн 20%-иас хэтрэхгүй байх учиртай юм. Боломж Олгох Сан нь Монгол улсад эрчимтэй хөгжиж буй жижиг дунд үйлдвэрийн салбарт энгийн болон зээл болгон хөрвүүлэх боломж бүхий хувьцаа худалдан авах замаар хөрөнгө оруулах Монголын анхдагч хувийн эзэмшигчдийн хөрөнгийн сан юм.

Ашигтай бизнесийн загварыг бий болгож чадсан, чадварлаг менежментийн баг бүрдүүлсэн, цаашид зах зээл дээр тэргүүлэх байр суурь эзлэх чадавхи бүхий хувийн хэвшлийн компаниудад үйл ажиллагаагаа өргөжүүлэхэд нь шаардлагатай байгаа хөрөнгийг тус Сангаас олгох юм. Боломж Олгох Сан нь хэтийн ирээдүйд Монголын хөрөнгийг арвижуулах зорилготой гол төлөв хөдөө аж ахуй, дэд бүтэц, уул уурхайн үйлчилгээ болон хангамжийн салбарт үйл ажиллагаа явуулдаг компаниудад хөрөнгө оруулах юм. Сангаас хийх хөрөнгө оруулалтын хэмжээ нь нэг компанид дунджаар 2.5-с 7.5 сая ам. доллар байх болно.

Эдийн засгийн шилжилтийн үед үзүүлэх үр нөлөө

Боломж Олгох Сан нь гардан гүйцэтгэх арга барилаар аж ахуйн нэгжүүдэд үйл ажиллагааны болон стратегийн мэдлэг туршлага, ноу-хоу-г дамжуулах замаар Монгол дахь хувийн хэвшлийн хөгжилд хувь нэмэр оруулах юм. Санал болгож буй уг төслийн эдийн засгийн шилжилтийн үед үзүүлэх үр нөлөө нь дараах дөрвөн чиглэлээр илрэх болно:

- 1) Монгол дахь хувийн өмчийн зах зээлийн хөгжлийг дэмжинэ;
- 2) Урт хугацаатай санхүүжилтийн эх үүсвэр хомс эсвэл үгүй нөхцөлд хувийн эзэмшигчдийн хөрөнгийн сангууд нь хувийн хэвшилд, ялангуяа жижиг дунд хэмжээний компаниудад хөрөнгө оруулалт хийх санхүүгийн тогтвортой арга хэлбэр мөн гэдгийг нотлоно;

- 3) Техникийн, үйл ажиллагааны болон санхүүгийн дадал, ур чадварыг хөрөнгө оруулалт авч буй компаниудад шилжүүлнэ; мөн
4) Компаниудын засаглалыг сайжруулна.

Гэрээт компани

FI-APC Fund Management нь Кайман Арлаас хараат бус хязгаарлагдмал хариуцлагатай компани юм.

ЕСБХБ-ны санхүүжилт

Хувьцаа худалдан авах зориулалтаар 10 сая ам. доллар хүртэлх санхүүжилт хийх ба энэ нь Сангийн нийт хөрөнгийн 20%-с хэтрэхгүй байх ёстой.

Төслийн нийт дүн

Сангийн нийт хөрөнгө нь 50 сая ам. доллар байх болно.

Байгаль орчинд үзүүлэх нөлөө

ЕСБХБ-ны Үйл Ажиллагаанд Тавигдах Шаардлагын 2 ба 9 дэхь зүйл ангиудын дагуу тус Сан нь байгаль очны ба нийгмийн стандартуудыг хэрэгжүүлэх үүрэгтэй юм. Мөн ЕСБХБ-ны Хувьцаа Худалдан Авах Үйл Ажиллагаанд байгаль орчны ба нийгмийн журмыг баримталдаг ба энэ нь ЕСБХБ-ны байгаль очны ба нийгмийн үр нөлөө үзүүлэхүйц үйл ажиллагааны жагсаалтын дагуу явагдах шаардлагатай байдаг. Тус Сан нь мөн Олон Улсын Санхүүгийн Корпорацийн (ОУСК) байгаль орчны ба нийгмийн журмыг баримтлах үүрэгтэй ба ОУСК-н вэбсайт дээрхи Нийгмийн ба Байгаль Орчны Менежментийн Системд бүртгүүлсэн байх шаардлагатай. Хөрөнгө оруулалт авч буй компаниудын үйл ажиллагаа нь Монгол улсад баримтлагдаж буй байгаль орчин, нийгэм, эрүүл мэнд, аюулгүй байдал болон хөдөлмөр эрхлэлтийн стандартудад нийцэж байх шаардлагатай. Тус Сан нь жил бүр Байгаль орчны ба Нийгмийн Тайланг ЕСБХБ болон ОУСК-д гаргаж өгөх шаардлагатай. Уг тайланг гаргахдаа AESR гэх хоёр байгууллагын нэгдсэн тайлангийн маягтыг ашиглана. Энэхүү маягт, мөн ЕСБХБ болон ОУСК-ын хамтарсан Байгаль орчин ба Нийгэмд үр нөлөө үзүүлэхүйц үйл ажиллагааны жагсаалт зэрэг баримт бичиг нь хууль эрх зүйн баримт бичгийн багцад орсон байх болно.

Техникийн Хамтын Ажиллагаа

Үгүй.

Холбоо барих

Mr Mandar Jayawant, Managing Partner
Email: mandar.jayawant@fidp-funds.com

Хамтран ажиллах боломжууд

Хамтран ажиллах, эсхүл худалдан авах үйл ажиллагаанд оролцох хүсэлтэй талууд гэрээт компанитай холбоо барина уу.

Ерөнхий асуулт, лавлагаа

Худалдан авах үйл ажиллагаанаас бусад ЕСБХБ-ны төслийн тухай лавлагааг:
Tel: +44 20 7338 7168; Fax: +44 20 7338 7380
Email: projectenquiries@ebrd.com

Мэдээллийг олон нийтэд түгээх бодлого

ЕСБХБ-ны стратеги, үйл ажиллагаандаа баримталдаг бодлого зэргийг олон нийтэд хэрхэн хамгийн дөхөм байдлаар хүргэх талаар холбогдох талуудтай зөвлөлдөх замаар ЕСБХБ-ны талаархи мэдээллийг олон нийтийн хүртээл болгодог юм.

[Мэдээллийг олон нийтэд түгээх бодлого](#)

Төслийн талаархи санал гомдол хүлээн авах механизм

ЕСБХБ нь үйл ажиллагаандаа Төслийн талаархи санал гомдол хүлээн авах механизмыг мөрдлөгө болгодог. Аливаа бие даасан байгууллага буюу хувь хүн энэхүү журмын дагуу ЕСБХБ-ны санхүүжилтээр хэрэгжиж буй төслийн үйл ажиллагааны талаар, ялангуяа хор хохирол учруулж буй эсхүл учруулж болзошгүй үйл явдлын талаархи санал гомдлыг хүлээж авдаг юм. Энэхүү журмыг бүрэн эхээр нь дараах холбоосоор орж сонирхоно уу: www.ebrd.com/downloads/integrity/pcmrules.pdf, мөн уг баримт бичгийг Орос хэл дээр доохи холбоосоор орж уншиж болно: <http://www.ebrd.com/downloads/integrity/pcmrulesr.pdf>

Энэхүү журмын дагуу аливаа санал гомдлыг ЕСБХБ-ны санхүүжилтийн эцсийн шилжүүлэг хийгдсэнээс хойш 12 сарын дотор ирүүлсэн байх шаардлагатай. Төслийн талаархи санал гомдол хүлээн авах механизмын ажилтантай холбоо барихын тулд дараах хаягаар хандана уу: pcm@ebrd.com, эсхүл ЕСБХБ-ны Монгол дахь Суурин Төлөөлөгчийн газрын ажилтнуудтай холбоо барьж санал гомдлыг хэрхэн хүргүүлэх талаар туслалцаа зөвлөгөө авч болно.

Төслийн Тойм Баримт Бичгийг уг төсөл нь ЕСБХБ-ны Захирлуудын Зөвлөлийн хурлаар хэлэлцэгдэхээс өмнө боловсруулдаг юм. Төсөл хэлэлцэгдэх ба батлагдах явцад төслийн талаархи зарим мэдээлэлд өөрчлөлт орж болно. Төслийн Тойм Баримт Бичгийг ЕСБХБ-ны албан ёсны бодлого хэмээн үзэж болохгүй.

Сүүлд шинэчлэгдсэн огноо 2010 оны 6-р сарын 22